БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 10 сарын 26 өдөр Дугаар А/229 Улаанбаатар хот

"Хүндэтгэл бахархал-2026"
арга хэмжээ зохион байгуулах

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 62 дугаар зүйлийн 62.1.1, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.10, 7 дугаар зүйлийн 7.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн 387 жилийн ойг угтан Дэлхий, тив, Олон улс, Улсын аварга шалгаруулах тэмцээн уралдаанд амжилттай оролцож дүүргийнхээ нэрийг гаргасан өсвөрийн баг тамирчид, хүүхдүүдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг 2026 оны 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсугай.

2.Арга хэмжээг зохион байгуулахад зарцуулагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталсугай.

3.Зарцуулагдах 4,915,000 (Дөрвөн сая есөн зуун арван таван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Арга хэмжээг чанар үр дүнтэй зохион байгуулах Ажлын хэсэг (Х.Цогцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

AJIL\2026 он ажил\захирамж

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 10 дугаар сарын 16 ны өдрийн
А/229 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

“ХҮНДЭТГЭЛ БАХАРХАЛ” АРГА ХЭМЭЭНД ОРОЛЦОХ БАГ ТАМИРЧИД

№	Баг, тамирчдын нэрс	Баг, тамирчдын тоо	Гаргасан амжилт
1	Таеквондогийн “Алтан шонхор” клуб	6	Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдсан ITF таеквондогийн Азийн аварга шалгаруулах XI тэмцээнд - Цэвэгдоржийн Сүндэръяа “Алтан” медаль - Нацагдоржийн Мөнхжин “Мөнгөн” медаль - Нацагдоржийн Дамдиндорж “Мөнгөн” медаль
2	Баттулга овогтой Өсөх-Ирээдүй	1	Азийн цомын аварга шалгаруулах Кикбоксын тэмцээнд - 56кг-ын жинд “Аваргын бүс”-ийн эзэн "ГАРДАН ТУЛААНЫ" Улсын аварга шалгаруулах тэмцээнд 16-17насны ангилалд - -58кг жинд “Мөнгөн” медаль, Солонгос улсад болсон ALLFC холбооны Олон Улсын тэмцээнд - Кикбоксын тулаанд “Алтан” медаль, WARFC холбооны Мэргэжлийн халз тулааны - 51кг C CLASS ангилалд аварга Дэлхийн аварга шалгаруулах - Бүгд Найрамдах Солонгос Улсын Инчён хотноо зохион байгуулагдсан ALLFC холбооны Дэлхийн аварга шалгаруулах - Кикбоксын төрөлд 55 кг-ын, 17–19 насны ангилалд аваргын бүс, Алтан медаль
3	Талын гэгээ-1 хамтлаг	12	Бүгд найрамдах Хятад ард улсын “Торгоны зам” Олон улсын хүүхэд залуучуудын урлагийн наадамд - “Морьтон охид” бүжгээр “Гранпри” шагнал “World Dance Festival-2026” олон улсын тэмцээнд Ардын бүжгийн төрөлд - "Аягат" бүжгээр Алтан медаль - Сонгодог төрөлд "Мөнгөн" медаль
4	Талын гэгээ-2 хамтлаг	16	Бүгд найрамдах Хятад ард улсын “Торгоны зам” Олон улсын хүүхэд залуучуудын урлагийн наадамд - “Их хүлгэн” бүжгээр “Алтан” медаль

			“World Dance Festival-2026” олон улсын тэмцээнд - “Их хүлгэн" бүжгээр Мөнгөн медаль - Сонгодог төрөлд "Мөнгөн" медаль - Хип хоп төрөлд "Хүрэл" медаль
5	Багахангай–Цэц шагайн харвааны клуб	18	- Улсын баяр наадмын Үндэсний шагайн харваанд 8 дугаар байр - Нийслэлийн Үндэсний шагайн харваанд тэргүүн байр Алтан медаль - Нүүдэлчин фестивал шагайн харваанд тэргүүн байр - Таван толгойн 60 жилийн ойн шагайн харваанд 5 дугаар байр - Хадбаатар аваргын нэрэмжит Үндэсний шагайн харваанд тэргүүн байр “Онч мэргэн” чимэг зүүсэн.
6	Цэц–Баян шагайн харвааны клуб	12	- Улсын баяр наадамын Үндэсний шагайн харваанд А.Хашэрдэнэ ахлагчтай баг “Мөнгөн” медаль, Жигбарал ахлагчтай баг “Хүрэл” медаль. - Булган аймгийн Булган хангай уухайд А.Хашэрдэнэ ахлагчтай баг “Алтан” медаль - Улсын сар шинийн харваанд А.Хашэрдэнэ ахлагчтай баг “Алтан” медаль - Говийн бүсийн чуулга харваанд А.Хашэрдэнэ ахлагчтай баг “Алтан” медаль - Говийн бүсийн Даншин наадамт А.Хашэрдэнэ ахлагчтай баг “Мөнгөн” медаль - Төв аймгийн Энх мэндийн харваанд А.Хашэрдэнэ ахлагчтай баг “Алтан” медаль

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн
А/229 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Ундаа	ш	65	2500	162,500
2	Жигнэмэг	ш	65	2500	162,500
3	Зууш	хүн	65	16,000	1,040,000
4	Жимс	кг	8	12,500	100,000
5	Гарын бэлэг	ш	65	50,000	3,250,000
6	Шатахуун / АИ92/	л	30	5200	165,000
7	Урилга, батламжны цаас	боодол	1	35,000	35,000
Нийт					4,915,000